



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/120

Ховд

Зөвлөгөөн зохион байгуулж, хөрөнгө  
гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “а”, төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулагдаж буй “Ховд аймгийн барилгын салбарын удирдах ажилтнуудын сургалт, зөвлөгөөн-2019” зөвлөгөөнийг 2019 оны 03 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсугай.

2.Зөвлөгөөнд шаардагдах 2 000 000 төгрөг /хоёр сая/-ийг Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг сайжруулах дэд хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Багдал/ -д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДУГЭРЖАВ

Zax A/120 Ch  
02 00542